

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2018 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нийгмийн хамгааллын чиглэлээр

1. Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулах ХНХЯ-ны холбогдох газрын дарга, мэргэжилтнүүд, НДЕГ болон дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга мэргэжилтэн, ТББ-ын судлаач эрдэмтэн, МХЕГ-ын мэргэжилтэн, МҮЭХ, МАОЭНХ-ны төлөөлөл, МУИС-ийн багш нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажлын 10 хоног ажиллаж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслүүдийн эхний хувилбаруудыг боловсруулаад байна.
2. Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018 оны 09 дүгээр тогтоолоор байгуулсан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийг нэмэгдүүлэн 7 жил болгосон нь тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх, даатгуулагчийн эрх ашгийг хэрхэн хөндөж байгаа талаар санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулах, тус Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий” ажлын хэсэгт ажиллаж тооцоо, судалгаа, танилцуулгыг боловсруулав.
3. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулсан “Үндэсний тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн талаар Засгийн газарт чиглэл өгөх” ажлын хэсэгт орж ажиллалаа.
4. Дэлхийн банкны төслийн хүрээнд хийгдэх Тэтгэврийн даатгалын сангийн актуарын ажлын даалгаварт тэтгэвэр тогтоох, тэтгэврийн доод хэмжээ болон тэтгэврийн суурь дүнгийн аргачлалыг тодорхойлох, тэтгэврийг индексжүүлэх болон тэтгэвэр тооцох цалингийн итгэлцүүрийг хэрэглээний үнийн болон улсын дундаж цалингийн өөрчлөлттэй уялдуулан тооцох аргачлалыг тодорхойлох, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тэтгэврийг бодох томьёонд өөрчлөлт оруулах тооцоолол хийх, нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэх ажлын хэсгээс шаардсан бусад тооцоолуудыг хийлгэхээр санал тусгаж оруулав.
5. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 2 дахь үе 2018-2020 шатны төлөвлөгөөнд малчдыг нийгмийн даатгалтай холбоотой малчдын нөхөн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг улсын төсөв, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд шийдвэрлэж малчдыг нийгмийн даатгалд хамрагдах сэдэл, сонирхлыг төрүүлж ирээдүйд нийгмийн баталгаа хангагдах боломжийг бүрдүүлэх; гэрээт ажилчид, туслах малчдын нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор “Ажил олгогч-малчин”-ы тусламжтайгаар нийгмийн даатгалд хамруулах гэсэн саналыг нэмж оруулав.
6. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад нийгмийн даатгалын мэдээллийн санд ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хуурамчаар оруулах, шимтгэл төлөгчийн тайланг устгах, засварлах, тайлангаа буруу, зөрүүтэй гарган ирүүлэх зэрэг асуудлууд үүсч байгаа тул Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авах, хянах, баталгаажуулах журмыг батлах шаардлага гарч байгаа ба дээрх асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ыг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар батлуулав.

Журмын төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах, баталгаажуулах нөхцөл бүрдэж, Нийгмийн даатгалын байгууллага, ажил олгогч нэг мөр ойлголттой болох юм.

7. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2017-2018 оны улсын нэмэлт хэлэлцээрийн хүрээнд тусгасан эрүүл мэнд, нийгмийн даатгалтай холбоотой биелэлтийг гаргав.
8. Нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдаар батлуулав. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын гишүүдээс санал авахаар хүргүүлээд байна.
9. “Малчин-даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр” гарын авлагыг боловсруулж, Европын холбооны санхүүжилтээр хэвлүүлэн Нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэв.
10. “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, НДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэв.
11. “Даатгуулагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах тухай журам”-д оруулах саналыг боловсруулж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлэв.
12. Тэтгэвэр барьцаалсан зээлийн хүү, зээлийн эргэн төлөлтийн талаар иргэдээс болон Монголын ахмадын холбооноос ирүүлсэн саналын дагуу тус газар НДЕГ-тай хамтран Хаан банк, Төрийн банкны зээлийн бодлогын газар, салбар нэгжүүдэд ажиллаж зээл олголтын явц, зээл олгох журам, зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, зээл олголтын тооцоо хийх програмтай танилцаад дараах дүгнэлтийг гаргасан болно.
13. “Эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлийн нөөцийн сан”, “Нөөц хөрөнгийн банкинд хадгалуулах журам”-д санал боловсруулж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлэв.
14. “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хууль”-ийн төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХНХ-ын сайдын 2018 оны А/95 тоот тушаалаар батлуулав.
15. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тушаалын төслийг боловсруулж, ХНХ-ын сайдын 2018 оны А/96 тоот тушаалаар батлуулан НДЕГ-т хүргүүлэв.
16. “Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн хуралдаанаар ажлын хэсгийн гишүүдэд хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалсан судалгааг танилцуулж, цаашид ажиллах ажлын төлөвлөгөөний талаар санал, бодлоо солилцов.
17. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай”, “Нийгмийн халамжийн тухай” хуулиудын хэрэгжилт болон ХХҮЕГ-ын үйл ажиллагаатай танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах УИХ-ын НББСШУБХорооноос байгуулсан ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаатай танилцан, иргэдтэй уулзав.
18. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан “Тайгад амьдардаг цаатан иргэнд тэтгэмж олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, батлуулав.
19. АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төсөл (L3086-MON)”-ийн хүрээнд хэрэгжүүлэх “Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарын сургалтын хөтөлбөр боловсруулах, семинар зохион байгуулах дотоодын зөвлөх байгууллагын ажлын даалгавар”, “Нийгмийн даатгалын

- шимтгэл төлөлтийн тайлангийн мэдээллийг цахимжуулах зөвлөхийн ажлын даалгавар /1995-2005 он/-ын төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч эцэслэн боловсруулав.
20. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 80 хувьд олгох тооцоо, судалгааг хийв.
 21. Тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2012 оны 136 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолыг батлууллаа.
 22. Засгийн газрын 2012 оны 136 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг боловсруулан 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 96 дугаар тогтоолоор батлууллаа.
 23. Эрүүл мэндийн яамтай хамтран Эрүүл мэндийн хөгжлийн төвд “Байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 69/А/48 тушаалыг мөрдөж эхлэхтэй холбогдуулан цахим сургалтыг 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгууллаа.
 24. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын Улаан загалмайн нийгэмлэг хооронд 2017 онд байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд 2018 онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсрууллаа.
 25. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид магадлан итгэмжлэл олгох сонгон шалгаруулалтанд улсын хэмжээнд 138 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага материалаа ирүүлснээс магадлан итгэмжлэх Орон тооны бус зөвлөл шаардлага хангасан 121 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид магадлан итгэмжлэлийн гэрчилгээ олгохоор шийдвэрлэв. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэхэд баримтлах аргачлал, зааврыг шинэчлэн батлуулж, ХХҮЕГ-тай хамтран ажиллалаа.
 26. ЗГХЭГ-ын даргын 2018 оны 04 сарын 17-ны өдрийн 108 дугаар тушаалаар ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, амьжиргааны эх үүсвэргүй, гэр оронгүй иргэдийн талаар цаашид авах арга хэмжээний чиглэлээр тодорхой санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсантай холбогдуулан гэр оронгүй, тэнэмэл иргэдийн талаар танилцуулга, мэдээлэл цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулав.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаанд шаардлагатай хөдөлмөрийн зах зээлийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилтийн байдлын нэгдсэн тоон мэдээллийг боловсруулж, тайланд тусгалаа.
Мөн судалгааны тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааны хүрээнд Европын холбооны Эстони, Испани, Латви, Литви зэрэг улс, Азийн БНСУ, БНХАУ-ын ижил төсөөтэй хууль тогтоомжийн туршлагыг судалж тайланд тусгалаа.
2. Дэлхийн банкны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд боловсруулах бичиг баримт болон холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулан ажиллаж байна. Үүнд:
Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар яамдаас санал авч нэгтгэн, тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулж, хөлсөөр ажилллах гэрээг байгуулан, холбогдох материалыг Сангийн яаманд хүргүүлэв.

3. Япон Улсад дадлагажигч зуучлах тусгай зөвшөөрөлтэй 65 байгууллагад хяналт шалгалт хийн, үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/23 тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэлээ.
4. Мэргэжлийн боловсролын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчилж байгаатай холбогдуулан мэргэжлийн боловсролын салбарын нийтлэг 12 албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулав.
5. Мэргэжлийн боловсролын салбарын багш нарын цалин, нэмэгдэл, урамшууллыг ерөнхий боловсролын багш нарын цалин хөлстэй харьцуулсан судалгаа, тооцоо хийв.
6. "Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам", "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох журам"-ыг тус тус боловсруулж, 2018.04.03-ны өдрийн 1/956 тоот бичгээр БСШУСЯ-нд санал авахаар хүргүүлэв.

Хөдөлмөр, цалин хөлсний чиглэлээр

1. УИХ-ын НББСШУ-ны Байнгын хорооны 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар болон Улсын Их Хурлын 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн нэгдсэн чуулганаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэн, дэмжив.
2. Төрийн 94 байгууллагаас ирүүлсэн цалингийн сан, төрийн албан хаагчдын тоог ангилал, зэрэглэл, цалингийн шатлалаар нэгтгэн боловсруулж, төрийн албан хаагчдын тоо болон цалин хөлсний талаар танилцуулга, төрийн албан хаагчдын цалин нэмэгдүүлэх үндэслэл, тооцооллыг боловсруулсан бөгөөд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд цалин нэмэгдүүлэх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоох үндэслэл, тооцооллыг боловсруулав.
3. Засгийн газрын хуралдаанд цалин нэмэгдүүлэх асуудлаар хийх нэмэлт хэлэлцээнд Засгийн газраас баримтлах чиглэлийн төсөл, хэлэлцээний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлах тухай захирамжийн төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
4. Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлогыг шинэчлэх төсөлд ажлын хэсгийн гишүүдийн саналыг тусган 2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр ажлын хэсэгт танилцуулан хэлэлцүүлж, гарсан саналуудын дагуу төслийг эцэслэн танилцуулга, тооцооллыг боловсруулж байна.
5. Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны хуралдаанд цалин нэмэгдүүлэх асуудлаар танилцуулга боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын Боловсрол,соёл, шинжлэх ухааны үйлдвэрчний холбоо болон Багш нарын цалин нэмүүлэх түр хорооноос цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох, цалингийн нэмэлт хэлэлцээ хийх зэрэг санал, шаардлагад хариу бэлтгэж хүргүүлээ.
6. Хөдөлмөрийн өдөр тэмдэглэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлээ.
7. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэх тооцоо, 2019 онд нэмж шаардагдах хөрөнгийг тооцоо боловсруулагдсан бөгөөд соёл, урлаг, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх ажлын удирдамж, ажлын байрыг ангилах аргаар үнэлэх аргачлалын төсөл боловсруулав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр

1. “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н дэлхийн өдрийг угтан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран “Эрх чөлөөний талбайд” 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр нээлтийн арга хэмжээг зохион байгуулав.
2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлага, хяналтын тогтолцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 02-нд Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран зохион байгуулж, шилдэг илтгэлийг шалгаруулав.
3. Ажлын байрны тоос, гэрэлтүүлэг, шуугианы стандартын төслүүдийг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдад танилцуулж, хэлэлцүүллээ.
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай мэдээллийг Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хилийн цэргийн удирдах газар, Нийслэлийн авто замын газар, Барилгын хөгжлийн төв, Номин констракшн ХХК, Эко констранкшн ХХК зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын 500 гаруй ажил олгогч, ажилтнуудад өгөв.
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс зохион байгуулсан арга хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримталж буй бодлого”-ын талаар мэдээлэл хийж, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцан, сургалт семинар зохион байгууллаа.
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд Монголын радио, MNB, SBN, TV5, MNC, MHTV, TV8, 25TV, like HD зэрэг телевизийн нэвтрүүлгээр олон нийтэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сэдвээр мэдээлэл өглөө.
7. ХБНГУ-ын физик техникийн хүрээлэнгээс зохион байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартын талаарх сургалт семинарт оролцов.
8. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, сонгон шалгаруулалтыг эхлүүлээд байна.
9. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж батлууллаа.

Хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр

1. Гэр бүлийн тухай хуулийн төсөл, дагалдан боловсруулах хуулиуд, яамдын саналын харьцуулалтыг бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжих зөвшөөрлийг ХЗДХЯ-наас аваад байна.
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг дагалдан гарсан журмуудыг хянаж сайжруулах, Гэр бүлийн хөгжлийн үндэсний хөтөлбөр боловсруулах, гэр бүлийн боловсролын сургалтын модуль боловсруулах ажлыг эхлүүлээд байна.
3. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн төлөвлөгөөт хяналт шалгалтын тушаалын төсөл боловсруулав.
4. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын байнгын ажлын хэсгийн хурал зохион байгуулав.
5. УИХ-ын НББСШУС-ын Байнгын хороонд хүүхдийн асуудлаар мэдээлэл бэлтгэж, хүргүүлэв.

6. “Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх” журмын төслийг эцэслэн боловсруулж, яамдаас дахин санал авч, ЗГХЭГ-т хүргүүлэхээр бэлтгэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудлыг хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байгуулахаар УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулан яамдаас санал авч, ЗГХЭГ-т хүргүүлэв. 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барихаар тогтов.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдагч мэдээллийн сан байгуулах үзлэг, тооллого зохион байгуулах тухай ХНХ-ын сайд, ҮСХ-ны даргын хамтарсан А/89, А/42 тоот тушаалыг батлууллаа. Үзлэг тооллогын бэлтгэлийг хангах, иргэдээс мэдээлэл цуглуулах асуулгыг эцэслэх зорилгоор Туршилтын үзлэг, тооллогыг зохион байгуулах ажлын удирдамж, төсвийг боловсруулан ХНХ-ын сайдын А/92 тоот тушаалаар батлуулав. Туршилтын үзлэг, тооллогыг Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант, Сэлэнгэ аймгийн Орхон сумдад зохион байгуулна.
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Улаанбаатар хот дахь байгууллагуудад хүртээмжийн үнэлгээ хийх ажлын удирдамжийг ХНХ-ын сайдын А/93 тоот тушаалаар батлуулав. Үнэлгээ хийх байгууллагуудад удирдамж болон тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл хүргүүлэв. Хүртээмжийн үнэлгээний ажлыг энэ чиглэлээр мэргэшсэн ТББ-ын төлөөлөл бүхий 3 баг хийж байгаа бөгөөд 04 дүгээр сарын 23-наас 05 дугаар сарын 23-ны хооронд нийт 40 орчим байгууллагыг хамруулах юм.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ТББ-ын төлөөллийг оролцуулсан ээлжит “Мэдээллийн цаг” арга хэмжээг зохион байгуулав. Тус мэдээллийн цагаар ЭМЯ-ны хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр 2017 онд хийсэн үйл ажиллагаа, 2018 оны төлөвлөгөө, Эмнэлэг хөдөлмөр магадлалын комиссын үйл ажиллагааны тухай болон Тэгш нийгэм ТББ-тай хамтран боловсруулж байгаа “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний стандарт”-ын төслийг танилцууллаа. Уг арга хэмжээнд нийт 60 гаруй байгууллагын төлөөлөл оролцож, оролцогчдоос 10 гаруй санал гарч, 20 гаруй асуултанд хариулт өглөө.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрны шалгаруулалтад аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын материалыг хүлээн авч 2018 оны 04 дүгээр сарын 06-нд нээсэн. Энэхүү хөтөлбөрт 134 аж ахуй нэгж, төрийн бус байгууллага оролцсон байна. Дээрх төслийн шалгаруулалтыг хуулийн дагуу хийж байна.
6. Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Салбар комиссын ээлжит хуралдаанд оролцож, Салбар комиссын үйл ажиллагааны явц болон тулгамдаж буй асуудалтай танилцаж, чиглэл арга зүйгээр хангав. ХНХ-ын сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”, “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур, үзүүлэлт”, “Байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүүхдийг тодорхойлох заавар” батлагдсантай холбогдуулан уг тушаалыг хэрэгжүүлж ажиллах эмч, мэргэжилтнүүдэд зориулсан цахим сургалтыг ЭМЯ-ны харьяа ЭМХТ, ХНХЯ-ны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран ЭМХТ-ийн Цахим сургалтын танхимд зохион байгуулж салбар комиссын 88 эмч мэргэжилтнүүдийг хамруулав.

Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр

1. Жендэрийн үндэсний хорооны 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, ажлын төлөвлөгөө, шийдвэрийн төслийг албажуулах хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийн сайд, Жендэрийн үндэсний хорооны дарга У.Хүрэлсүхэд хүргүүлэв. ЖҮХ-ны 2018 оны 01 тоот тогтоолоор хорооны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, 02 дугаар тогтоолоор хорооны дэргэдэх Хэвлэл мэдээллийн зөвлөлийг, 03 дугаар тогтоолоор жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийг, 04 дүгээр тогтоолоор эрдэмтэн судлаачдын бүлгийг тус тус байгууллаа.
2. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийн талаарх 8, 9 дүгээр нэгтгэсэн илтгэл хэлэлцүүлгээс Монгол Улсад хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх салбар дундын ажлын хэсгийн шинэчилсэн бүрэлдэхүүн, зөвлөмжийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг ХНХ-ын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/98 дугаар тушаалаар батлуулав.
3. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их хурлын Байнгын хорооны 2018 оны 01 сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын тайланг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 3/1069 тоот албан бичгээр хүргүүлээ.
4. Жендэрийн үндэсний хорооны дүрмийг Засгийн газрын хуралдаанаар батлууллаа.
5. Удирдах ажилтнуудад зориулсан Жендэрийн цахим сургалтын модулын эхний төслийг АХБ-ны ТА9201-MON төслийн Жендэрийн зөвлөх баг, Мэдээлэл харицааны зөвлөх баг, ЖҮХАА, АХБ-ны холбогдох ажилтнуудаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулав. Тус модулыг 5 дугаар сард багтаан дуусгаж, Сангийн яам болон түүний харъяа байгууллага, агентлагийн удирдах ажилтнуудад сургалт зохион байгуулж, турших юм.
6. МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн хичээлийн хөтөлбөрт Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг тусгах, батлуулах ажлыг гүйцэтгэх зөвлөхийн хураангуй жагсаалтыг гаргаж, тендерийн баримт бичгийг хүргүүлэв.
7. ЖҮХ-ны цахим хуудсыг хийхэд шаардлагатай мэдээллүүдийг бэлтгэн гүйцэтгэгч байгууллагад хүргүүлж ажилласан бөгөөд цахим хуудсыг сүлжээнд байршуулж, ажиллуулж эхлээд байна.

Бусад

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд цалин хөлс, нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр санал боловсруулж, хүрэх түвшин, холбогдох төсвийн тооцооллын мэдээллийг тус тус бэлтгэн Сангийн сайдад албан тоотоор хүргүүлээ.
2. Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо 2018 оны 04 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд болсон Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын ээлжит долдугаар хуралдаанд холбогдох газрын дарга оролцов.
3. АНУ-ын Нью-Йорк Хотноо 2018 оны 04 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан НҮБ-ын Хүн ам ба хөгжлийн хорооны комиссын чуулганд холбогдох газар, хэлтсийн дарга нар оролцов.